



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/471

Номгон

Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12/54 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 6.1.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, иргэдэд тогтвортой хөгжлийн боловсрол ногоон хөгжлийн боловсрол олгох сургалт, арга хэмжээг 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Иргэд, олон нийтэд байгаль орчны хууль тогтоомжийг сурталчлан таниулж, экологийн мэдлэг, хандлага, төлөвшлийг олгох олон талт ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

842311228